



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРААР ҮЙЛЧЛҮҮЛЖ БУЙ ИРГЭДЭЭС АВСАН 2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын Нэг цэгийн үйлчилгээний тасагт иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.



СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

График1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс:



Дүгнэлт: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаанд 99 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 60 иргэн буюу 60.6% эмэгтэй, 39 иргэн буюу 39.4 % нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.


График2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд авч үзвэл 20-хүртэл 1 иргэн буюу 1%, 20-29 насны 8 иргэн буюу 8.1% , 30-39 насны 26 иргэн буюу 26.3%, 40-49 насны 23 иргэн буюу 23.2% , 50-59 насны 29 иргэн буюу 29.3%, 60-аас дээш 11 иргэн буюу 11.1% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.



График3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 99 иргэдийн тэтгэвэртэй холбоотой үйлчилгээг 36 иргэн буюу 36.4%, тэтгэмж 24 иргэн буюу 24.2%, сайн дурын даатгал 15 иргэн буюу 15.2%, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт 5 иргэн буюу 5.1%, бусад үйлчилгээ 8 иргэн буюу 8.1%, зөвлөгөө мэдээлэл 11 иргэн буюу 11.1% тус бүр авсан байна.

Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар:




Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн 61 иргэн буюу 61.6%-н маш сайн үнэлгээг өгсөн, сайн үнэлгээг 32 иргэн буюу 32.3%, дунд үнэлгээг 6 иргэн буюу 6.1%, муу, маш муу үнэлгээг өгөөгүй байна.




Зураг2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээллээ бүрэн авсан байдал:

Мэдээллээ бүрэн авч чадсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 99 иргэнээс “Тийм” гэсэн үнэлгээг 95 иргэн буюу 96% “Үгүй” үнэлгээг 4 иргэн буюу 4% өгсөн байна.

Зураг3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ:




Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжтай 95 иргэн буюу (96%) сэтгэл дундуур 4 иргэн буюу (4%) тус бүр үнэлсэн байна.

Зураг4:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал /Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц,худалдан авах ажиллагаа./




Мэдээлэл ил тод байдаг уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 99 иргэдийн Тийм үнэлгээг 60 иргэн буюу (60.6%), Үгүй үнэлгээг 9 иргэн буюу (9.1%), Мэдэхгүй үнэлгээг 30 иргэн буюу (30.3) тус бүр үнэлсэн байна.

Зураг5: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан үйлчилгээ авсан уу?




Дүгнэлт: Судалгаанд оролцсон 99 иргэдийн “Тийм” үнэлгээг 9 иргэн буюу 9.1%, “Үгүй” үнэлгээг 90 иргэн буюу 90.9% тус бүр үнэлсэн байна.

Зураг6: Түүвэр судалгаанд оролцсон иргэд үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив туслалцаа үзүүлж байсан уу?



ИРГЭДИЙН ТОО



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчаас “Тийм” үнэлгээг 4 иргэн буюу 4.0%, “Үгүй” үнэлгээг 95 иргэн буюу 96% тус бүр үнэлсэн байна.

Асуулт 10. Та төрийн байгууллагын авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж үзэж байна вэ?

Иргэдийн санал, гомдол

- ✓ Ажилдаа хариуцлагатай, үнэнч шударга байх
- ✓ Нээлттэй ажлаа явуулах
- ✓ Төрийн албан хаагч шударга шуурхай хүнд сурталгүй тэгш үйлчилгээ үзүүлэх
- ✓ Авлига өгч үзээгүй болохоор мэдэхгүй байна
- ✓ Хууль дүрмээ баримтлах
- ✓ Цахим үйлчилгээг сайн нэвтрүүлэх
- ✓ Авлигаас хол байж ард иргэдийн төлөө үнэн зөв үйлчилвэл сайн байна
- ✓ Бүх үйл ажиллагааг хянадаг камержуулалт сайн байх
- ✓ Үйлчилгээ шуурхай ойлгомжтой байвал авлига өгөх шаардлагагүй байна
- ✓ Шилэн байвал зүгээр байх
- ✓ Удирдлага зөв байх

СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ ХИЙСЭН:

АХЛАХ ТӨЛӨӨЛӨГЧ: Н.ШҮРЭН-ЭРДЭНЭ